



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй,
байгаль орчны чиглэлээр дэвшүүлсэн
2025 оны зорилго, зорилтыг батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам" -ын дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалт, 23 дугаар зүйлийн "ж" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулах, түүнд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллахыг нийт бүтцийн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

2. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны 2025 оны зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх бүх шатны оролцоог тодорхойлох тухай"-ыг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг ханган ажиллах чиглэлээр өөрийн байгууллагын хэмжээнд ажлын төлөвлөгөө гаргах, тодорхой албан тушаалтанд танилцуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, сар бүр авч хэлэлцэх зэрэг бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллахыг нийт бүтцийн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг бүх алба, хэлтэс, төв, тасаг, салбар нэгжид, Хэрэгжилтийг хангуулж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны дарга (А.Энх-Амгалан)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Замын ерөнхий инженер (Бондарь Д.В.)-д тус тус үүрэг болгосугай.

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хяналтыг сайжруулах арга хэмжээний шаардлагатай зардлыг санхүүжүүлэхийг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я.)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601250006

“УБТЗ” ХНН-ийн даргын 2025 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын
хавсралт



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны зорилго,
зорилт, түүнийг хэрэгжүүлэх бүх шатны оролцоог тодорхойлох тухай

“Улаанбаатар төмөр зам” ХНН (цаашид “Нийгэмлэг” гэх)-ийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, ослоос урьдчилан сэргийлэх урт хугацааны бодлого “Vision Zero” (Ослыг тэглэх алсын хараа)-г хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, бүх шатны удирдлагын манлайлал нийт ажилтнуудын оролцоотойгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны түвшнийг дээшлүүлэх, хяналтыг сайжруулан ажиллахад энэхүү тушаалын зорилго орших бөгөөд бүтцийн нэгжүүд дараах зорилтот ажлыг зохион байгуулж ажиллана. Үүнд:

1. Дараах зорилтот арга хэмжээний гүйцэтгэлтийг хангуулах;

1.1. Аюул, эрсдэл өндөртэй үйлдвэрлэлийн хэсэгт осол эндэгдэл гаргахгүй байх чиглэлээр урьдчилан сэргийлж ажиллах;

1.2. УБТЗ-ын хэмжээнд үйлдвэрлэлийн осолгүй ажиллах зорилго, зорилтыг мөрдөж ажиллах;

1.3. Аюултай, хортой хэвийн бус нөхцөлтэй нийт ажлын байрны нэгээс доошгүй хувийг хэвийн нөхцөл рүү шилжүүлэх;

1.4. МУ-ын ХАБЭА-н тухай хуульд зааснаар нийт төсвийн 1,5-аас доошгүй хувийг ХАБЭА-н зардалд тусгаж, зардлын зөв хуваарилалт, ажлын байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

1.5. Ажилтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөлд өртөх эрсдэлийг хэмжих, бууруулах үр дүнтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

1.6. ХАБЭА-н менежментийн тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх бүх шатны манлайлал, оролцоо, бүтээлч сэтгэлгээг дэмжин урамшуулах;

1.7. “УБТЗ” ХНН-ийн нийт ажлын байруудад байгаль орчинд ээлтэй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёл, зөв дадлыг түгээх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хэмжих, бууруулах, арилгах;

2. Дээрх зорилтод хүрч ажиллахын тулд бүх түвшний удирдлагуудад даалгах нь:

2.1. Зорилтын хүрээнд 2025 онд бүтцийн нэгжийн хэмжээнд ХАБЭА, БО-ны чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг өмнөх оны эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангах;

2.2. ХАБЭА-н зөвлөлийг хагас жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулж, ISO 45001:2018 стандартын дагуу удирдлагын дүн шинжилгээг жилд 2 удаа хийх;

2.3. ХАБЭА-н чиглэлээр бусдыг үлгэрлэн манлайлж, нийт ажилтны оролцоотойгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадлыг бий болгох зорилгоор ажилчидтай нээлттэй харилцан яриа өрнүүлэх, санал

асуулга авах, саналын хайрцаг ажиллуулах болон бусад ижил төстэй арга хэмжээг зохион байгуулж, бүтээлч сэтгэлгээг дэмжин урамшуулах;

2.4. Аюул, эрсдэлд цаг тухайд нь бодит үнэлгээ хийж, аюулыг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ төлөвлөн, биелэлтийг ханган ажиллах;

2.5. Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдал, хортой хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах зорилгоор дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэн, нөөцийг үр дүнтэй удирдан чиглүүлж, үйлдвэрлэлээс шалтгаалсан ажилтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах;

2.6. Бүх түвшний ажилтны хэрэгцээг үндэслэн ХАБЭА-н сургалтыг цаг тухай бүрд чанартай зохион байгуулах, үр дүн, үр нөлөөг тооцох;

2.7. ХАБЭА-н бодлого, зорилтыг үр дүнтэй чиглүүлж, нормативын гүйцэтгэлд биечлэн оролцож, аюул эрсдэлийг бодитоор илрүүлэх, үр дүнг хянах тогтолцоог төлөвшүүлэх;